



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2018 ОН**

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

1.1. Удирдлага зохион байгуулалт	2
1.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа.....	2
1.3. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлт.....	2
1.4. Сургалтын үйл ажиллагаа	3
1.5. Санхүү, хөрөнгө оруулалт	4
1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ.....	5
1.7. Хяналт шалгалтын талаар	5

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР.

2.1. Хууль, тогтоомж.....	5
2.2. Сайдын шийдвэр.....	6
2.3. Стандарт, норматив	7
2.4. Хуулийн байгууллагад төлөөлөн оролцсон байдал.....	7

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:..... 8

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Авто зам	9
4.2. Авто тээвэр	10
4.3. Төмөр зам.....	11
4.4. Агаарын тээвэр	12

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР..... 12

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР..... 13

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 05 дугаар сарын 02

Улаанбаатар

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

1.1. Удирдлага зохион байгуулалт

Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын 2018 оны төлөвлөгөөний дагуу зөвлөлийн хуралдааныг 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж 2 асуудал /“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийн тухайн/ хэлэлцэж шийдвэрлэсэн.

Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 227 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн яамны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих журам”-д заасны дагуу сайдын шуурхай зөвлөгөөнийг 4 удаа зохион байгуулж яамны нэгж, харьяа байгууллага, агентлагт нийт 39 үүрэг, даалгавар өгөгдсөнөөс хэрэгжилт 71%-тай, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж 19 үүрэг, даалгавар өгөгдсөнөөс хэрэгжилт 82%-тай байна.

1.2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Тус яаманд 2018 оны 04 дүгээр сард нийт 870 бичиг ирснээс хариутай 470 бичиг, хариугүй 400 бичиг, шийдвэрлэсэн 243 бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд орууллаа.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-134, Төрийн захиргааны удирдлагын газарт-194, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-179, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-115, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-103, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-62, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-75 шилжүүлсэн байна.

Ирсэн бичгийг байгууллагаар нь ангилж үзвэл: Монгол Улсын Засгийн газраас-13, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас-30, УИХ-ын гишүүн, байнгын хороодоос-16, яамдуудаас-160, Элчин сайдын яамдаас-3, Авилгатай тэмцэх газраас-5, Төрийн

албаны зөвлөлөөс -5, аймаг, орон нутаг-45, дүүрэг, хорооноос-1, шүүх, цагдаагийн байгууллагаас-29, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдээс-40, харьяа байгууллагаас-140, компаниас-218, холбоодоос-26, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас-143 бичиг ирсэн байна.

Агуулгаар нь ангилбал: Санал авах-72, хүсэлт гаргах, хүргүүлэх, уламжлах-258, гүйцэтгэл, санхүүжилт хүссэн-23, тусгай зөвшөөрөл-32, шагнал-25, хариу ирүүлсэн-146, биелэлт, тайлан, мэдээ ирүүлсэн-83, мэдээлэл авах-3, асуудал шийдвэрлүүлж дэмжлэг хүссэн-16, бусад 212 бичиг тус тус байна.

Яамнаас гадагш-531 албан бичиг явуулж 10806 хуудас сканердаж able программд оруулсан.

Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар -87, Төрийн захиргааны удирдлагын газар-144, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар- 121, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-49, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-65, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-27, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-38 албан бичиг явуулсан.

1.3. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлт:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн яаманд 2018 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар иргэдээс нийт 114 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 105, хуулийн хугацаа нь болоогүй шийдвэрлэхээр судлан хяналтад байгаа 8 өргөдөл бөгөөд шийдвэрлэлтийн хувь 92,1%-тай байна.

Өргөдөл, гомдлыг илгээгчийн төрлөөр ангилахад иргэнээс 51, ажилтнаас 63 ирүүлсэн.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцагийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтан ажиллаж байна.

1.4. Сургалтын үйл ажиллагаа:

Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2018 оны сургалтын төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор давхардсан тоогоор 106 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Тухайлбал:

1. Авилгатай тэмцэх газраас зохион байгуулж буй дараах сургалтад яамны болон яамны харьяа байгууллагын албан тушаалтнуудыг хамруулсан. Үүнд:

- Нийтийн албанд анх орсон албан хаагч нарт зориулсан сургалтад 10 албан хаагч,

- Нийтийн албан тушаалтны сургалтад 40 албан хаагч,

- Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтад 25 албан хаагч,

- Бусад нэгжийн удирдах албан тушаалтны сургалтад 1 албан тушаалтан

- Захиргаа, удирдлагын нэгжийн дарга нарын сургалтад 1 албан тушаалтан тус тус хамрагдсан.

2. Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалт, төрийн удирдлагаар мэргэшүүлэх “Гараг”-ийн сургалтад төрийн зардлаар 1 албан хаагч,
3. “Аялал жуулчлал ба чөлөөт бүсийн хөгжил” сэдэвт сургалтад 1 албан хаагч,
4. АХБ-ны зохион байгуулсан 2018 оны 4 сарын 12-13-ны өдрүүдэд явагдсан “EIDIC” гэрээний сургалтад 5 албан хаагч,
5. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх биоаюулгүй байдлыг Хангах үндэсний хорооноос зохион байгуулсан “Био аюулгүй байдал био хамгаалал сэдэвт” сургалтад 2 албан хаагч,
6. Сангийн яам, Бүгд Найрамдах Турк Улсын Эдийн засгийн яамтай хамтран зохион байгуулж буй “Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Туркийн чөлөөт худалдааны хэлэлцээр” сэдэвт сургалтад 2 албан хаагч,
7. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын “Монгол Улсад газар өмчлүүлсний үр дүн, цаашдын зорилт” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.

1.5. Санхүү, хөрөнгө оруулалт:

- Сайдын багцын харьяа төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог Сангийн сайдын баталсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилт болон зарцуулалтын эрхийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сард нийт 175 ширхэг 10,5 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгаж төсвийн тухай хууль болон холбогдох журам дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн хянан баталгаажуулж ажилласан.

- Хөрөнгө оруулалтын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээ, цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээг Засгийн газрын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.

- Норм, нормативын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж, Үндэсний аудитын газраас хянуулж байна. Тус санд 2018 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар авто зам, замын байгууламжийн барилгын ажлын санхүүжилт болон норм, стандарт, техникийн баримт бичиг борлуулснаас нийт 116,777,308 төгрөгийн орлого орж, 50,216,170 төгрөгийн зарлага гарсан байна.

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 7 төсөл, арга хэмжээний 7,003,305,708.59 төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу гүйцэтгэгчийн дансанд олгосон.

- Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу 11 төсөл, арга хэмжээний 2,850,625,374.67 төгрөгийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг Сангийн яамнаас эрх нээсний дагуу чөлөөлж, гүйцэтгэгчийн дансанд олгосон.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2017 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилт, худалдан авах ажиллагаа, зураг төсвийн судалгааг заавар, маягтын дагуу гарган, хөрөнгө оруулалттай холбоотой холбогдох материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

- Яамны албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсаар олгож байгаа бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар бичиг хэргийн зардал 10,470,600. төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 3,465,738 төгрөг, шуудан, холбоо, интернетийн төлбөрт 4,166,925 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна.

1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн биелэлт, сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал шийдвэрүүдийн биелэлтүүдийг 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

- Зам, тээврийн хөгжлийн яамны газар, хэлтсийн дарга нарын 2018 оны 1 дүгээр улирлын үр дүнгийн гэрээний хэрэгжилт, газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох арга хэмжээг авсан.

- Зам, тээврийн салбарын норматив, баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн 2016-2017, 2017 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт, санал зөвлөмж өгөв.

1.7. Хяналт шалгалтын талаар:

- Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Төрийн нарийн бичгийн даргын 38-07-003/08 дугаартай удирдамжаар Баян-Өлгий, Ховд аймгийн Автотээврийн төв, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 4 аж ахуйн нэгж /“Цэнгэлтранс” ХХК, “Байшинт ямаан ус” ХХК, “Зорчигч тээвэр ховд” ХХК болон “Аумин” ХХК/-ийн үйл ажиллагаанд 2018 оны 04 дүгээр сарын 02-06-ны хооронд хяналт шалгалт хийв.

Шалгалтаар нийт 101 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 38 заалт бүхий 3 албан шаардлагыг 4 аж ахуйн нэгжид, улсын байцагчийн 01-111/04-07-037/09/09 тоот актаар Баян-Өлгий аймгийн Автотээврийн төвийн үйл ажиллагааг зогсоож, зөрчил гаргасан 3 аж ахуйн нэгжид 1.950.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ тус тус авсан.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомж:

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.114-т тусгагдсан Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн чиглэл, барих үе шат, уртыг Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д нэмэлтээр тусгаж УИХ-аар батлуулахаар УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдаар 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр батлуулсан.

Зам, тээврийн салбарт мөрдөгдөх дараах хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хянаж, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэхээр боловсруулж байна. Үүнд:

1. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,
2. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
3. Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
4. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Дээрх хуулийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулахаас гадна яамны цахим хуудаст байршуулан санал авч байна.

2.2. Сайдын шийдвэрээр:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 81 дүгээр тушаалаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын нарийвчилсан төлөвлөгөөг шинэчлэн батлав.

- Зам, тээврийн хөгжлийн сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2018-2020 онд хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр байгуулав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 84 дүгээр тушаалаар Увс аймгийн Наранбулаг сумын Харганатын төмрийн хүдрийн ордоос Ховд аймгийн Булган сумын нутагт байрлах Цоохор нуурын агуулах хүртэл тээвэрлэх улс хоорондын тээвэрлэлтийн чиглэлийг батлав.

- Зам, тээврийн салбарт мөрдөж буй захиргааны хэм хэмжээний актыг хянаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 82 дугаар тушаалаар захиргааны хэм хэмжээний 26 актыг хүчингүй болгов.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн "Хөрөнгө захиран зарцуулах эрх шилжүүлэх тухай" 70 дугаар тушаалаар олон улс болон улсын чанартай авто замын тэмдэг, тэмдэглэгээг "Авто замын тэмдэг Техникийн ерөнхий шаардлага" MNS 4597:2014 стандартад нийцүүлэн шинэчлэн, сайжруулах ажлын хүрээнд анхааруулах, хориглох болон мэдээллийн самбарын тоо хэмжээ, тухайн ажилд шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т үүрэг өгөв.

- "Зам, тээврийн салбарт агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2018 онд хийгдэх ажлын төлөвлөгөө"-г боловсруулан Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар 2018 оны 04 дүгээр сарын 03-ний өдөр батлав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт, хяналтыг сайжруулах тухай" 04 тоот албан даалгаврыг батлав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын шийдвэрээр батлагдах дараах баримт бичгийн төслийг боловсруулж байна. Үүнд:

1. "Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил, дээшлүүлэх мэргэжлийн зэрэг олгох" журмын төсөл,

2. "Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам"-ын төсөл, "Авто замын ашиглалтын бэлэн байдлын төвшингээр санхүүжүүлэх журам"-ын төсөл

3. "Төмөр замын мэргэжилтэн ажилтан бэлтгэх, мэргэшлийн зэрэг олгох, шалгалт авах журам"-ын төсөл,

4. "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм"-ийн төсөл,

5. "Усан замын тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм"-ийн төсөл,

6. "Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг бэлэн байдлын төвшингээр үнэлж санхүүжүүлэх журам"-ын төсөл,

7. "Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөн, мэдээлэх журам"-ын төсөл

8. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журмын төсөл,

9. “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-ийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус боловсруулж байна.

2.3. Стандарт, норматив:

- “Авто тээвэр (ТХ15), Авто зам (ТХ15/ДХ01), Төмөр зам, далай ашиглалт, усан тээвэр (ТХ33), Иргэний нисэх (ТХ34)-ийн салбарын стандартчиллын техникийн хороодын 2018-2019 оны стандартчиллын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны хуралдааныг 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр тус яамны хурлын зааланд зохион байгуулж, “Иргэний нисэх. Нисэхийн хөдөлгөөнт холбооны хэт өндөр давтамжийн хэмжээ MNS... 2018” стандартын төслийг хэлэлцэн дэмжиж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

- “Зам төмрийн толгойн түвшинд авто угсрааны өндөр шалгах загвар. Баталгаажуулалтын арга хэрэгсэл” стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжлийн техникийн хороогоор хянуулан төмөр замын салбарын болон хэмжлийн лабораторитой байгууллагуудаас санал авч байна.

- “Төмөр замын тээврийн хэрэглээ. Ачааны вагон үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулж, вагон бүхий аж ахуй нэгж байгууллагаас санал авч байна.

- “Зам, тээврийн салбарын норматив, баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн 2018 оны төлөвлөгөөний дагуу

1. “Цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх станцад тавигдах ерөнхий шаардлага” стандарт боловсруулах ажлын даалгавар,

2. “Авто замын тээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдал, үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын ажлын даалгавар,

3. “Тусгай зориулалтын авто замыг ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын судалгаа”-ны ажлын даалгаврыг тус тус боловсруулж байна.

2.4. Хуулийн байгууллагад төлөөлөн оролцсон байдал:

1. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох дараах хэрэгт шүүхэд төлөөллөөр оролцож Зам, тээврийн хөгжлийн яамны талд шийдвэрлүүлсэн. Үүнд:

- “Хотгор зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.488 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн үнийн өсөлтийн зөрүү 2.484.870.155 төгрөг гаргуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.

- “Гашууны гол” ХХК-ийн нэхэмжлэлтэй Хяналтын шатны 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн шүүх хуралдаанаар “Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 95,4 км хатуу хучилттай авто замын Багц -III БОЛОХ 27,75 км замын ажлын гэрээний үнийн өсөлтийн зөрүү 1.503.860.293 төгрөг гаргуулах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлэв.

- Иргэн С.Баяраагийн нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн давж заалдах шатны 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн шүүх хуралдаанаар Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж тус яамны талд магадлал гарсан.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны эрх ашгийг хамгаалах зорилгоор Ажил гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй дараах компаниудыг шүүхэд хариуцагчаар татаж нэхэмжлэл гаргав. Үүнд:

- Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд “Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар хороонд баригдах 1.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажил”-ын урьдчилгаа санхүүжилт болох 31.400.000 /гучин нэгэн сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг гүйцэтгэгч “Композит Асмо” ХХК-аас гаргуулах тухай,

- “Хархорин-Хужирт” чиглэлийн 36,8 км хатуу хучилттай авто замын хоёрдугаар хэсэг 15,4 км замын барилгын ажил”-ыг гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 276,000,000 /хоёр зуун далан зургаан сая төгрөг /-ийг гүйцэтгэгч “Аваргас” ХХК-иас гаргуулах тухай,

- “Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км асфалтбетон хучилттай авто замын барилгын ажил”-ыг гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 663.480.000 /зургаан зуун жаран гурван сая дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг “Нутгийн зам” ХХК-иас гаргуулах тухай нэхэмжлэлийг тус тус гаргасан.

3. Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй “Чайна гео инженеринг корпораци” ХХК-д холбогдох иргэний хэрэгт шинжээч оролцуулах тухай хүсэлтийг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан боловч тус шүүхийн шүүгч Д.Ганболд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 101/Ш32018/05297 дугаар захирамжаар шинжээч оролцуулахаас татгалзсан бөгөөд уг захирамжид 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/1490 тоот албан бичгээр Шүүхийн ерөнхий зөвлөлд гомдол гаргасан.

4. Зам, тээврийн хөгжлийн яаманд холбогдох “Пик девломент” ХХК, “Хотгор зам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах хүсэлтийг Улсын Ерөнхий Прокурорын газарт хүргүүлсэн.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

- “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-ын 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар батлуулав.

- “УБТЗ” ХНН-ийн 1998-2015 онуудад төлсөн дизелийн түлшний онцгой албан татварын 73.8 тэрбум төгрөгийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкнаас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээл, зээлийн хүү, алдангиас суутгуулан тооцуулах асуудлыг Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-аар шийдвэрлүүлэхээр болсон бөгөөд УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.04.24-ний 01/1783 тоот албан бичгээр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

- Тээвэр, авто замын газрыг 21 аймагт байгуулах асуудлаар судалгаа, тооцооны үндсэн дээр танилцуулга бэлтгэн Засгийн газрын гишүүдээс саналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/1520 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07-р хуралдаанаар өгөгдсөн үүрэгт нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн

газрын Хэрэг эрхлэх газарт Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/1520 тоот албан бичгээр хүргүүлэв.

- “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.04.13.-ны 01/1642 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр болов.

- “Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг бууруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын гишүүдээс саналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/1725 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

- “Туршилт судалгаа хийх” тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж санал авахаар Засгийн газрын гишүүдэд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/1793 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Индонези Улсын Бали хотноо 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Камбожийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг батлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар Зам, тээврийн дэд сайдын 2018.04.13-ны 02/1643 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн.

- “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийн Монголын талын хувь эзэмших төрийн өмчит компани байгуулах, дүрмийн санг шийдвэрлүүлэх, хамтарсан хуулийн этгээдийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох шийдвэрийн төслийг бэлтгэн санал авахаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.04.25.-ны 01/1833 тоот албан бичгээр, Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

4.1.Авто зам:

Авто замын салбарт 2018 онд Монгол Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний талаарх мэдээлэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 2019-2020 онд эхлүүлэхээр төлөвлөж байгаа авто замын төслүүдийн жагсаалтыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1897 тоот албан бичгээр Мэдээлэл холбооны операторуудын ассоциацид хүргүүлсэн.

Мөн Харилцаа холбооны тухай хуулийн 27.1.1-д “инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, барилга байгууламж барих, шугам, сүлжээ байгуулахдаа үйлчлэгчээс зөвшөөрөл авах, түүнийг шилжүүлэх шаардлагатай бол уг ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх”, 29.4-д “Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газарт ажил гүйцэтгэх бол үйлчлэгчээс урьдчилан зөвшөөрөл авна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа гүйцэтгэгч компаниуд болон авто замын засвар арчлалтын нийт 47

компаниудад 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 03/1891 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Авто замын барилгын ажлын чиглэлээр 2018 оны 03 сард зарлагдсан тендерүүд дараах нөхцөл байдалтай байна. Үүнд:

1. Сонгон шалгаруулалт хүчинтэй болж гүйцэтгэгч компани шалгарсан

- Хараа голын 135 у/м төмөр бетон гүүрийн засварын ажил /Дархан, Дархан сум/ гүүрийн барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер,
- Дорнод аймгийн Цагаан-овоо сумын галын голын 36.7 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер,
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” дахь XIV.1.1.39 “Ширээгийн голын 90.9 у/м төмөр бетон гүүр /Завхан, Цагаанхайрхан сум/-ын барилгын ажлын гүйцэтгэгчээр “ЗЗБ” ХХК, “Эвт-Уул” ХХК шалгарсан.

2. Сонгон шалгаруулалтын үнэлгээ хийгдэж байгаа

- Дундговь аймгийн зам хариуцагчийг сонгон шалгаруулах тендер,
- “Хорооллын доторх авто замын засвар, 3 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/” түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр гүйцэтгэх тухай цахим тендер,
- “Туул зөрлөг орчмын төмөр замын доорх автомашины нүхэн гарц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/” түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр гүйцэтгэх тухай цахим тендер,
- Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн авто замын төгсгөлийн хатуу хучилттай авто зам, 22 км /Булган/ ажил гүйцэтгэх тухай цахим тендер,
- Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумын авто замын зураг төсөл боловсруулах тендер, “Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын нүхэн гарц /Дархан-Уул, Дархан сум/” тендер,
- Баян-Өлгийн аймгийн Улаанхус сумын Согоогийн голын төмөр бетон гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг тус тус нээж үнэлгээ хийгдэж байна.

3. Сонгон шалгаруулалт хүчингүй болсон

- Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72 у/м /Увс, Улаангом сум/ гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер,
- Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий, Дадал, Баян-Адарга сум/ гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер,
- “Туул голын Сонгинын төмөр бетон гүүр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/” түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй төслийн зураг төсөл боловсруулах, гүүрийн барилгын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер,
- Мандалын голын төмөр бетон гүүр /Баянхонгор, Галуут сум/ төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер тус тус хүчингүй болсон.

4.2.Автотээвэр:

- “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн I шатанд 43 автобусны хуваарилалт Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, “ДиБиЭм” ХХК, “Чингис хаан банк”-ны оролцоотой 3 талт гэрээ /116, 117 дугаар

“Дамжуулан зээлдүүлэх гэрээ”/-ний дагуу 15 аж ахуйн нэгж, байгууллагад 35 автобусыг хүлээлгэн өгсөн ба 8 автобус авах хүсэлт гаргасан 3 аж ахуйн нэгжийн хүсэлтийг судлаж байна.

- Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яам хоорондын Протоколд өөрчлөлт оруулах асуудлаар БНХАУ-ын талтай 2018 оны 04 дүгээр сарын 03-04-ний өдөр Бээжин хотноо хэлэлцэн тохирч, Протоколыг үзэглэв.

- Польш, Унгар, Литвийн талаас ирүүлсэн автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн орчуулгын ажлыг дуусгасан бөгөөд хэлэлцээрт ойрын үед гарын үсэг зурах саналыг Монгол Улсын Гадаад харилцааны яамаар уламжлуулан Польш, Унгар, Литвийн талд хүргүүлэв.

- Мэргэшсэн жолоочийн эрх авах шалгалтын цахим системд дараах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа бөгөөд энэ асуудлаар “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т үүрэг чиглэл өгөв. Үүнд:

1. Оюуны өмч, улсын бүртгэлийн газартай мэдээлэл солилцох, хамтран ажиллахдаа мэргэшсэн жолоочийн эрх авах шалгалтад орж буй иргэнийг өөрийн хурууны хээгээр бүртгэх, шалгалтыг эхлүүлэхдээ хурууны хээгээр нэвтрэх боломжийг нээж өгөх;

2. ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвтэй мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллахдаа мэргэшсэн жолоочийн эрх авах шалгалтад хамрагдах иргэн нь өөрийн хүссэн ангилалд шалгалт өгөх эрх байгаа эсэхийг шалгах боломжийг бүрдүүлэх;

3. Мэргэшсэн жолоочийн эрх авах шалгалтанд оролцох иргэний шалгалт өгч буй хугацаанд нь фото зургийг авч баталгаажуулах, мөн давтан өгөх тухай бүрд нь зургаар баримтжуулах;

4. Мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын байгууллагын автотээврийн хэрэгслийг бүртгэхдээ улсын дугаар, арлын дугаарыг хийж, тээврийн хэрэгслийн бүртгэлийн системээс үлдсэн мэдээллийн татаж авах.

4.3.Төмөр зам:

- Засгийн газрын 2017 оны 245 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Япон Улсын буцалтгүй тусламжаар Замын-Үүд суманд баригдсан төмөр замын шилжүүлэн ачих цогцолборын дэргэд баригдсан 60 айлын 5 орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах асуудлыг шийдвэрлэв.

Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх, тээврийн хэрэгслээ бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авах асуудлаар иргэд болон Хөвсгөл нуурт усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй завьчдын холбооны удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

- Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, бүртгэх, улсын дугаар олгох шинэчилсэн журмын төсөл, нөлөөллийн шинжилгээ, танилцуулгад санал авах, Зам, тээврийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2014 оны тушаалыг хүчингүй болгох тухай 01/1796 тоот албан бичгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэв.

- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 11 ААН, байгууллагын материалыг хянан шалгаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 77 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.

- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах болон сунгуулах хүсэлт ирүүлсэн 8 ААН,

байгууллагын материалыг хянан шалгаж 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэсэн.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний 76 дугаар тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн угсрах, үйлдвэрлэх, засварлах, чиглэлээр таван аж ахуй нэгжид зургаан тусгай зөвшөөрлийг олгосон.

4.4. Агаарын тээвэр:

- Иргэний нисэхийн ерөнхий газар “Захиалагч”-аар, “Үүрэг трейд” ХХК “Гүйцэтгэгч”-ээр байгуулсан “Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилга”-ын ИНЕГ /ТББ/БУ-47/10/93 дугаартай гэрээт ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр ИНЕГ /ТББ/БУ-47/10/93-34/18 дугаартай гэрээг 2018 оны 04-р сарын 06-ны өдөр байгуулсан.

- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-аас хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн хугацааг сунган, 2019 оны 07 дугаар сар хүртэл үргэлжлүүлэхээр харилцан шийдвэрлэж, талууд баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан.

- Иргэний нисэхийн ерөнхий газар, төслийн зөвлөх “Азуса Сэkkэй-Ориентал Консалтантс Глобал” хамтарсан түншлэл хооронд 2009 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан” Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2 дугаар нэмэлт өөрчлөлтөд талууд 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 123, 2017 оны 04 дүгээр тушаалаар тус тус томилогдсон Улсын комисс Япон Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баригдсан “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмжид хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн 1278 зөрчилд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар ахлуулсан Улсын комисс 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр газар дээр нь үзэж танилцан, уулзалт зохион байгуулсан.

- Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан Японы консорциумын төлөөлөлтэй Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр уулзалт хийж шинэ нисэх буудлын менежмент төслийн хэлэлцээг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс үргэлжлүүлэх, Ерөнхий сайдын 2017 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар тус тус шийдвэрлэсэн.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1. Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 04 сарын 03-ны өдөр ОХУ-ын Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизовыг хүлээн авч уулзаж зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

2. Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн 2018 оны 04 дүгээр сарын 09-12-ны өдрүүдэд БНХАУ-д хийсэн айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд орж ажилласан.

3. Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Бинали Йылдырымын 2018 оны 04 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Туркийн тээвэр, харилцаа холбооны сайд

Ахмет Арслантай уулзаж хоёр улсын зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

4. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгээр Зам, тээврийн салбарт хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн байдалтай танилцах, дараагийн шатны үйл ажиллагааг хэлэлцэх, эрчимжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл 2018 оны 04 дүгээр сарын 15-18-ны өдрүүдэд Япон Улсад ажлын айлчлал хийсэн.

5. Зам, тээврийн хөгжлийн яам, “УБТЗ” ХНН хамтран 2018 оны 04 дүгээр сарын 15-наас 18-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагддаг “Транс Россия” арга хэмжээний үеэр “Транзит Монгол-2018” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, ОХУ-д суугаа элчин сайдын яам, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ, тээвэр зуучийн байгууллагууд болон ОХУ, БНХАУ-ын холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл, төрийн бус байгууллага, холбоод болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд оролцлоо.

6. Турк Улсын Стамбул хотод 2018 оны 04 дүгээр сарын 15-21-ны хооронд болсон авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын инженерүүдийн 4 дахь семинар, КАРЕК -ын Тээвэр зохицуулалтын дэд хорооны 17 дугаар хуралдаанд төлөөлөл оролцов.

7. БНХАУ-ын Тан Шань хотын ЦаоФэй Диан дүүргийн Ардын засгийн ордноос ирүүлсэн Хятад-Гадаадын хамтарсан аж үйлдвэрийн эдийн засаг, худалдаанд төлөөлөл оролцов.

ЗУРГАА. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР.

- “Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д зорчигч тээврийн байгууллагууд, ачаа тээврийн байгууллагууд, техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн байгууллагууд, автотээврийн хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгууллагууд, эрдэмтэн судлаач, ТББ-ын төлөөллүүдийг оролцуулж 2018 оны 04 дүгээр сарын 20, 24 -ний өдөр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

- “Хот хооронд, орон нутгийн нийтийн тээвэрлэлтийн эрх зүйн орчинг сайжруулах, тээвэр зохион байгуулалтыг шинэ төвшинд хүргэх төлөвлөлт”-ийн талаар жуулчин болон ачаа тээврийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудыг хамруулан 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

- 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ӨМӨЗО-ны Хөгжил шинэчлэлийн хорооны төлөөлөгчидтэй зам, тээврийн салбарын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын асуудлаар уулзалт зохион байгуулав.

- “Автотээврийн эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр автотээврийн салбарын эрдэмтэд, судлаачдын дунд зохион байгуулсан.

- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” тусгай зөвшөөрөл эзэмшигч “Доктор авто сүлжээ” ХХК, “Ниватрейд” ХХК, “Автотерминал” ХХК-ийн удирдлагуудтай техникийн хяналтын үзлэгийн чанарыг дээшлүүлэх уулзалтыг 2018 оны 04 дүгээр сарын 27 нд зохион байгуулав.

- Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д нэмэлтээр тусгаж УИХ-

аар батлуулахаар УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсан бөгөөд УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Нортерн рейлвейс” ХХК, “Төмөр замын инженерүүдийн холбоо” ТББ болон төмөр замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, холбогдох ТББ-уудын төлөөлөл болон иргэдийн дунд зохион байгуулсан.

- 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Бетон замын технологийн өдөрлөг"-т оролцож, бусад улс орны цементбетон авто зам барих технологи, туршлагыг судласан.

- 2018 оны 4 дүгээр сарын 16-ний өдөр БСШУСЯ-нд хэрэгжиж буй АХБ-ны ТТ-9375 MON: Шинжлэх ухаан, технологи, инновацийн тогтолцоог хэрэгжүүлэх” төслийн хүрээнд Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын өнөөгийн байдал “Тулгамдаж буй асуудлууд ба сорилт” сэдэвт хэлэлцүүлэгт оролцов.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны “Хүүхэд хамгаалал үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт Зам, тээврийн хөгжлийн яамнаас авч хэрэгжүүлсэн ажлын талаар тайланг амжилттай хэлэлцүүлэв. Мөн “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн салбарын Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах салбар зөвлөл 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдаж, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ